

## Хануул дүүргийн Эрүүл мэндийн байгууллага

Хануул дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл нь олон жилийн түүхэн уламжлалтай, нийслэлийн ууган дүүргүүдийн анхны эрүүл мэндийн байгууллагын нэг юм.

1933 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Аж үйлдвэрийн даргын тушаалаар 2 орон тоотой эмнэлгийн анхны суурь тавигдсан. Эмнэлэг нь үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндээс гадна үйлдвэрийн болон ажилчдын байрны эрүүл ахуй ариун цэвэр, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн ухуулга сурталчилгааны асуудлуудыг хариуцан ажиллаж байна. Анхны эмнэлэгт ЗХУ-ын иргэн бага эмч О.Ф.Сидорова, асрагч Т.И.Никольский нар ажиллаж байлаа.

1934 оны 1 дүгээр сард нээгдсэнээс хойш 3 сарын дараа тус эмнэлэг нь 30 ортой больниц, шүдний кабинет, эмийн сантай болж өргөжсөн. Үйлдвэрийн ажилчдаас 5 хүнийг сувилагчийн түр сургуулиар сургаж үндэсний боловсон хүчнийг бэлтгэн ажиллуулж эхэлсэн байна.

Үйлдвэрийн захиргаа эмнэлгийн эм, хоол багаж тоног төхөөрөмж, боловсон хүчний цалин, сургалтыг бүрэн хариуцаж байснаас гадна хүнд өвчтөнд очиж үзэх, хүүхэд төрөх эмэгтэйчүүдийг эмнэлэгт хүргэхэд машин унаа дайчлах эрх олгох зэргээр эмнэлэгт ихээхэн анхаарал тавьж байсан.

Анхны үндэсний их эмчээр Д.Сэвжидмаа, Ц.Дэмид, Ц.Долгор, Л.Дамдинсүрэн нар ажиллаж байв.

1950 он Дотрын 25, хүүхдийн 25 бүгд 50 ортой болов. Энэ үеэс орон тоог нэмж 7 их эмч 4 бага эмч, 10 сувилагч цехийн бага эмч, 3 тус тус ажиллуулж эхэлсэн.

1957 он Эмнэлгийн оношлог оо эмчилгээний багаж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж анхны рентген аппаратыг ашигласан. 1960 онд орон тоог 75 болгов. 1966 онд Буянт-Ухаагийн салбар амбулатори байгуулагдав. Анхны цехийн хэсгийн эмнэлгийн ажиллуулж эхэлсэн байна.

1979 онд дүүргийн 120 ортой Хүүхдийн нэгдсэн эмнэлэг байгуулагдав.

1988 он Цехийн хэсгийн эмнэлэг 24 болж өргөжив.

1991 оны 03 дугаар сарын 14-ний Удирдах газруудын шийдвэрээр бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Ажилчны районы нэгдсэн эмнэлэг, "Ажилчин" Эрүүл мэндийн зөвлөх төв, Нийслэлийн Эрүүл мэндийн 13-р төв гэсэн нэртэйгээр ор бүхий эмнэлэг, нарийн мэргэжлийн төвүүдийг тусад нь зохион байгуулав. Анхны даргаар Ц.Алимаа, Д.Цэрэндолгор, Долгормаа нар ажиллаж байв.

1997 оны ЭМНХ-ын сайдын тушаалаар мөн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Нэгдсэн эмнэлэг, Зөвлөх төвийг нэгтгэж "Хануул Эрүүл мэндийн нэгдэл"-ийн зохион байгуулав. Нэгдлийн анхны даргаар Д.Цэрэндолгор сонгогдон ажиллаж байна.

2000 оны 03 дугаар сарын Өрхийн эмнэлгүүдийг тусад нь "ББН" хэлбэрээр зохион байгуулж эхлэв, Дүүрэгт 12 өрхийн эмнэлэг байгуулагдав.

2001 оны 07дугаар сарын 01-ний өдрийн ЭМЯ-ны сайд Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал